

**Андураан дууг\* ангилал зүйгээр шинжих нь  
(хөгжмийн археологи судлалын илтгэл)  
(=Исследование «андуран дуу» с использованием  
системы классификации (доклад по музыкальной  
археологии))**

*Д. Ганпурэв<sup>1</sup>*

<sup>1</sup> Монгольская государственная консерватория (25, проспект Бээжин, 7-й квартал, округ Сухбаатар, 11000 Улан-Батор, Монголия)

научный сотрудник

E-mail: boertemusic@gmail.com

© КалмНЦ РАН, 2020

© Ганпурэв Д., 2020

**Аннотация.** Музыкальная находка, уникальная не только в истории этнической музыки Монголии, но и во всемирной истории и археологии, была обнаружена в скальных могилах в районе Жаргалант Хайрхан Ховдского (Кобдоского) аймака Монголии. Совместное исследование монгольских и немецких ученых, основанное на возрасте артефакта, подтверждает, что уникальная находка датируется VII–VIII вв. н. э. Эта музыкальная находка была успешно изучена монгольскими, немецкими и американскими учеными в области археологии, палеоантропологии, древней письменности и музыковедения. В дальнейшем изучение структуры этого оригинального артефакта, его частей, оригинального дизайна и классификации древних музыкальных инструментов может способствовать восстановлению одного из древнейших музыкальных инструментов, на котором исполнялся древний монгольский эпос, инструментом, который был утрачен на протяжении всей истории.

**Ключевые слова:** археологическая находка, многоугольник, дугообразный, классификация, определение категории (класса), номинация

**Благодарность.** Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой

---

\* Андурраан дуу гэдэг нь өвөг Монголчуудын «Алтан ундрага», «Хөх бодон» туулинд гардаг хүнгэнэн их туульсын хөгжимдүүрийн нэр. «Анхан Живэрлэгийн дүүргэн, Андурраан дуун хүнкэнэж, Алтан гургалдай, өвөөлжин, хур, Аяс дэмнэн ганганаж, Ариун хөг дэлгэрч, Аяс намуун шаг/цаг ирэвэ» хэмээн төрийн туульч, СГЗ, Баян-Алтайн удам дамжсан туульч Э. Баатаржаваас тэмдэглэж авав.

**Д. Ганпурэв Андурaan дууг ангилал зүйгээр шинжих нь  
(хөгжмийн археологи судлалын илтгэл)**

поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

**Для цитирования:** Ганпурэв Д. Андурaan дууг ангилал зүйгээр шинжих нь (Хөгжмийн археологи судлалын илтгэл) // *Desertum Magnum: studia historica*. 2020. № 2. С. 24–45. DOI: 10.22162/2712-8431-2020-10-2-24-45

UDC 780.6

DOI: 10.22162/2712-8431-2020-10-2-24-45

## **«Anduran duu» research using the classification system**

*Ganpurev D.*<sup>1</sup>

<sup>1</sup> Mongolian State Conservatory (25, Beijing Ave., Sukhbaatar district, 7<sup>th</sup> District, Ulaanbaatar 11000, Mongolia)

Researcher

E-mail: boertemusic@gmail.com

© KalmSC RAS, 2020

© Ganpurev D., 2020

**Abstract.** A musical artifact, unique not only in history of ethnic music of Mongolia, but also in world history and archeology was found in rock burials in the area of Zhargalant Khairkhan, Khovd aimak of Mongolia. A joint study of Mongolian and German scientists, based on the age of the artifact, confirms that the unique find dates back to the 7<sup>th</sup> and 8<sup>th</sup> centuries of our era. This musical artifact has been successfully studied by Mongolian, German and American scientists in the fields of archeology, paleoanthropology, ancient writing, line drawing and musicology. The author of the article admits that in the future, by studying the structure of this original artifact, its parts, the original design and classification of ancient musical instruments, one of the most ancient musical instruments on which the ancient Mongolian epic was performed, an instrument that was lost throughout history, can be restored.

**Keywords:** archaeological find, polygon, arcuate, classification, definition of a category (class), nomination

**Acknowledgement.** The article was presented at the international scientific online conference “Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects – II”, held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

**For citation:** Ganpurev D. «Anduran duu» research using the classification system. In: *Desertum Magnum: studia historica*. 2020. No. 2. Pp. 24–45. DOI: 10.22162/2712-8431-2020-10-2-24-45

## Оршил

Хаднаан булшнаас илэрсэн хөгжмийн олдворыг олон улсын судалгаа-Ханд угсаатны хөгжим судлал болон археологи судлалын хавсарсан аргаар судалдаг бөгөөд түүнийг хөгжмийн археологи судлал (lat. *music archeology study*), харин судлаачийг нь хөгжимийн археологич (lat. *music archaeologist*) гэж нэрлэдэг [Both 2009].

Жаргалант Хайрханы хөгжмийн олдвор нь археологи, палеоантропологи, эртний бичгийн судалгаа, зураасан зураг судлал, хөгжим судлалын хүрээнд амжилттай судлагдаж байгаа. Харин Монгол угсаатны хөгжим судлалын хүрээнд энэ олдвор бүрэн судлагдаагүй тул олдворын анхдагч загвар, хөгжмийн ангиллын асуудал, гарвал үүслийн хувьд монгол түрэг угсаатны эрдэмтэн судлаачдын дунд багагүй маргаан дагуулж байна. Олон улсын угсаатны хөгжим судлал, хөгжмийн археологи судлалын салбар энэхүү хөгжмийн олдвороор дамжуулж Монгол Түрэг угсаатны судлаачдаас бодит судалгааг хүлээсээр 10 гаруй жил өнгөрсөн. Тийм учраас Жаргалант Хайрханы модон хөгжим дүүрийн олдворыг эртний нүүдэлчдийн ахуй соёлын хүрээнд дахин судалж онцлогийг нь зөв тодорхойлох, эх олдворын нэр томъёоллын схемийг зохиож, эд ангиудыг нэршүүлэх, дутуу эд ангийг нөхөж судалгааны хүрээнд байж болох анхдагч загварыг гаргаж угсаа гарвалыг судлах нь Монгол угсаатны хөгжим судлалд төдийгүй, эртний нүүдэлчдийн хөгжмийн судалгаанд холбогдох нэн чухал эх хэрэглэгдэхүүн болж, судлаачдад санаа сэдэл терүүлэхэд тус дэм болох магадлалтай хэмээн үзэж байна. Тус хаднаан булшны хөгжмийн олдворын тухай бичгийн сурвалжид тэмдэглэгдсэн нь үгүй боловч өвөг Монгол туульд өгүүлсэн зарим зүйл бий.

«Алтан ундарга», «Хөх бодон» туульд өгүүлснээр:

*«...Анхан Живэрлэгийн дүүргэн*

*Андураан дуун хүнкэнэж*

*Алтан гургалдай, өвөөлжин, хур*

*Аяс дэмнэн ганганаж*

*Ариун хөг дэлгэрч*

*Аяс намуун шаг (цаг) ирэвэ...»* хэмээн нэгэн бүлэг дуусгаж бадаг холбоосыг ийнхүү хайлна. Энд гарч буй их Андуураан дууг Алтай ятгад холбогдуулан үзэж болохыг түүний тэвх үгүй тээг чавхдасын доргионоос сонсож нягталж болно хэмээн судлаач миний бие үзэж байна. Мөржим нь мөн болбоос хаднаан булшнаас илэрсэн модон хөгжимдүүрийн ангилал зүйгээр нь ялгаж, дутуу эд ангийг нь судалж, ижил төстэй бүл хөгжимдүүрийн түүх улбааг сонжиж эртний нүүдэлчдийн туульсын хөгжимдүүр мөн эсэхийг судлахыг зорив. Андуураан дууг ангилал зүйгээр нь шинжихэд хөгжмийн археологи судлалын арга зүй, археоакустикийн судалгаа нэн чухал.

## ҮНДСЭН ХЭСЭГ

### 1. Хөгжмийн эх олдворын ангиллын асуудалд

Олон улсын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй угсаатны эд өлгийн зүйлийг ангилдаг ангиллын системийг “Hornbostel-Sachs-Systematik” гэж нэрлэдэг [Hornbostel, Curt 1914].

Австри улсын эрдэмтэн Э. М. Хорнбостел, Герман улсын эрдэмтэн С. Закс нарын зохиосон энэхүүхөгжмийн ангилал зүйн системийг 1914 оноос хойш дэлхий дахинд мөрдөж байгаа бөгөөд Оросын угсаатны хөгжим судлаач К. А. Вертхов, Г. Благодатов, Э. Язовицкая нар өөрийн судалгаандаа энэхүү системийг түлхүү ашигладаг. Харин Америк, Европын угсаатны хөгжим судлаач, хөгжмийн археологчид энэхүү хөгжмийн ангиллын системийг мөрддөг тул хөгжмийн судалгааны хэлийг нь ойлгохын тулд “Hornbostel-Sachs-Systematik” ангилалын системийг бүрэн ойлгох шаардлагатай.

Угсаатны хөгжимд хамаарах бүх төрлийн хөгжимдүүрийг нэгэн их далай хэмээн ойлговол дэлхий дээрх бүх л хөгжмийн төрөл зүйл нь таван их урсгалаар энэ далайд цутгадаг гэж ойлгож болно. Мэдээж 1 500 жилийн өмнөх эртний нүүдэлчдийн хөгжмийн олдворыг энэ их орон зайгаас шүүрдэх амаргүй ч эртний хөгжимдүүрийн (lat. *ancient*) түүхэн үечлэл, ангиллаас энэхүүхөгжмийн олдворыг олж тогтооход Hornbostel-Sachs-Systematik ангилал зүйн судалгаа гол баримжааг чиглүүлнэ. Дэлхийн угсаатны хөгжмийн 5 их ай савыг доорх тоон түлхүүрээр чандлан хөгжүүлдэг. Үүнд:

**Индекс # 1** Idiophone буюу (Percussion) төмөр чулуун аялгууны хөгжмийн их ай.

**Индекс # 2** Membranophone буюу (Drum) арьс ширэн аялгууны хөгжмийн их ай.

**Индекс # 3** Chordophone буюу цуурайн хайрцагт чавхдаст хөгжмийн их ай.

**Индекс # 4** Aerophone буюу агаар, салхиаар дэмждэг хөгжмийн их ай.

**Индекс # 5** Elektrophone буюу цахилгаан хүчдэлээр дэмжигддэг орчин үеийн хөгжмийн их ай.

Хөгжмийн ангиллын эдгээр таван их айд хэдэн мянган угсаатны хөгжимдүүрүүд өөр өөрсдийн түүх, соёл, угсаатны онцлог, хөгжмийн төрөл зүйл, түүхэн үечлэлээрээ ялгарч оршдог. Жаргалант Хайрханы хөгжмийн олдвор нь цуурайн хайрцагт хөгжимдүүр мөн тул “Hornbostel-Sachs-Systematik” ангиллын **индекс # 3**-д хамаарах цуурайн хайрцагт чавхдаст хөгжмийн их айд хамаарна. Өрөөр хэлбэл, индексээр нь үргэлжлүүлэн хөгжлийн хувьслаар нь тодорхойлж, бүл хөгжимдүүрийн төрөл зүйл рүү нь мөшгиж судлах нь зүйтэй гэж үзэж байна.

### 1.1 Хөгжмийн олдворыг «Цуурайн хайрцагт чавхдаст хөгжим»-ийн их айд хамааруулахын учир

«Цуурайн хайрцагт хөгжимдүүр» буюу Chordophone гэдэг нь (lat. Chord, mong. Хам эгшиг, дуурьсал; lat. Phone, mong. дуу эгшиг хоолой) гэсэн утгатай ч тодорхойлолт нь тээг мод болон чавхдас татагчийн хооронд татсан чавхдасны чичиргээг хөгжмийн дуу авиа болгон хувиргадаг цуурайн хайрцагийг хэлнэ. Олон улсад ятга, ёочин зэргийг шууд утгаар нь кордофон гэж нэрлэх тохиолдол ч элбэг. Анхандаа ойлгохгүй байсан ч ангилал зүйн хувьд нь ажиглалт хийснээр ийнхүү нэрлэх өөр нэг боломж өрнөдөд байдаг юм байна гэдгийг ойлгосон. “Hornbostel-Sachs-Systematik” ангиллын схемийн дагуу цуурайн хайрцагт хөгжимдүүрийн аймгийг үндсэн хоёр бүлэгт хуваадаг.

(1) Хөгжимийн хүзүүгүй, шууд царнаас үүдэлтэй чавхдаст хөгжимдүүрийн бүл нь үндсэн их айд хамаарах # 3 гэсэн индексээр #1 гэсэн дугаарыг авч салбарлана. Үүнийг Индекс # 31 гэсэн дугаар гэж ойлгоно. Энэ бүлд энгийн цуурайн хайрцагт хөгжимдүүрүүд хамаарна. (lat. *Simple chordophones or zithers*).

(2) Хүзүүтэй чавхдаст хөгжимдүүрийн бүл. Индекс # 32 гэсэн дугаартай. Энэ бүлд хүзүү цар нийлмэл цуурайн хайрцагт чавхдас хөгжимдүүрүүд хамаарна (lat. *Composite chordophones*)

Ихэнх чавхдаст хөгжимдүүрүүд хоёрдугаар бүлэгт ордог боловч төгөлдөр хуур, хэвтээ ятга, цитарын төрлүүд нэгдүгээр бүлэгт хамаардаг.

Герман улсын эрдэмтэн Курт Закс цуурайн хайрцагт хөгжмийн аймгийн индекс # 31 бүлэгт нуман хуур (амны хөндийн тусламжтайгаар дэлдэж тоглодог), чавхдаст даралтат хөгжим (Клавикорд) нумалсан ятгууд (царны нүүр тэгш бус бага зэрэг нуман хэлбэртэй), төгөлдөр хуурын төрлийн хөгжимдүүр, ёочингийн төрлийн дэлддэг хөгжимдүүр, хөндий хулсан бөөрөнхий ятга (Валиха) болон ази болон дорнын хэвтээ ятгуудыг хамааруулсан (Монгол, хятад, японы бүл ятгууд хамаарна).

Харин индекс # 32 бүлгийг (321.1) товшуур (lutes), (321.2) лийрэн ятга (lyres), индекс # 322 бүлэгт босоо ятга (harps)-ын төрөл зүйлүүдийг авч үзсэн [Sachs 1940: 463–467].

(321.1) **Товшуур** (Lutes)-ын бүл зэмсэг нь хүзүүтэй, цуурайн хайрцагт чавхдаст хөгжимдүүрүүд орно. Үүнд: лүт, ут, пипа, гитар, товшуур, шанз, хобис зэрэг товшуур хөгжимдүүр хамаарахаас гадна хийлийн бүл, морин хуурын бүл, хуучирын бүл гэх мэт нумт чавхдаст хөгжимдүүрүүд салбарлана. Энэ нь нумт хөгжимдүүрийн хөгжилтэй холбоотой байх.

(321.2) **Лийрэн ятга** (Lyre) нь хоёр тулгуур гартай, түүнийг холбосон хөндлөвч модтой бөгөөд доод царнаас хоёр гарын хөндлөвч модруу чавхдасаар татсан хөгжимдүүр юм. Харахад лийр жимс мэт хэлбэртэй ч Lyre нь лийр гэсэн утга биш юм.

**Д. Ганпурэв Андурраан дууг ангилал зүйгээр шинжих нь  
(хөгжмийн археологи судлалын илтгэл)**

(322.1) **Босоо ятга** (harps) босоо цартай бөгөөд царнаас чавхдас татагч хөндлөвч рүү босоо хэлбэрээр чавхдасууд нь татагддаг. Хэвтээ ятгын бүл хөгжимдүүр шиг тэвх болон чавхдас тээглэгч мод байхгүй. Дотроо өнцөгт болон нуман ятга гэж ангилагдах бөгөөд эдгээр нь бусад ятгын бүл хөгжимдүүрээс тэвхгүйгээрээ ялгарна.

Жаргалант Хайрханы хөгжмийн олдвор нь хүзүүтэй хөгжимдүүр тул индекс #3.2 ангилал дахь (321) товшуурын төрлийн бүлд хамаарч болох хэдий ч энэ олдвор нь тэвх байхгүй зөвхөн чавхдас татагч тээг модтой тул энэ бүлд хамаарахгүй гэж үзэж байна. Олон улсын эрдэмтэд энэ ангилал дээр андуурах, эх олдворын судалгааг 321.321 индекст хамааруулан товшуурын төрлийн хөгжимдүүр, эсвэл морин хуурын төрөл зүйлд эндүүрэх тохиолдлууд нэлээн гарсныг судлаачид лавшруулан үзэх хэрэгтэй. Хөгжмийн ангиллын хувьд Туркийн саз, Казакын кобыз, Монголын морин хуурын хөгжимдүүрийн түүхийн хөгжилтэй огт холбоогүй бөгөөд **индекс # 3**—«Цуурайн хайрцагт чавхдаст хөгжмийн аймаг»-ийн, **индекс # 32** хүзүү, цар нь нийлмэл цуурайн хайрцагт хөгжмийн бүлийн **индекс # 322**-д хамаарах «Босоо ятга» (Harps)-ын бүл хөгжимдүүрт хамаарах **индекс # 322.12** «өнцөгт ятга» (angular harp)-ын төрлөөс нуман хүзүүгээрээ дамжин **индекс # 322.11** «Нуман ятга» (archedharp)-ын төрөлд андуурагдаж болох өвөрмөц хөгжимдүүрийн олдвор гэдэг нь энэхүү ангиллаас тодорхой харагдана. Тодруулж хэлбэл, Жаргалант Хайрханы хаднаан булшнаас илэрсэн модон хөгжимдүүр нь тал хээрийн нүүдэлчдийн өнцөгт ятгын язгуурын угшилтай нуман хүзүүтэй өнцөгт ятга бөгөөд хөгжмийн ангилалд шинэ нээлтийг бий болгосон эртний нүүдэлчдийн модон хөгжимдүүр юм гэсэн санааг дэвшүүлж байна.

Тус хөгжимдүүрийн талаар «Алтан ундарга», «Хөх бодон» зэрэг өвөг Монгол туулинд

*Анхан Живэрлэгийн дүүргэн*

*Андурраан дуун хүнкэнэж*

*Алтан гургалдай, өвөөлжин, хур*

*Аяс дэмнэн ганганаж*

*Ариун хөг дэлгэрч*


*Аяс намуун шаг/цаг ирэвэ ...* хэмээн хайлагддаг. Туулийн бүлэг, бадгийн холбоос нь хуучин бүхэн шинийн эхлэл болдог шиг анхан живэрлэгийн дүүргэн андуураан дуун хүнкэснээр аливаа хөгжлийн дээд шат дуусаж шинэ эрин эхлүүлдэг тухай өгүүлнэ.

Утга санааг шинжвээс Андурраан дууны хүнкэнээн нь тэвх үгүй тээг модноос, эсвэл цуурайн хайрцагны нүүрнээс шууд татсан чавхдаст хөгжимөөс үүсдэг болохыг дахин сэргээгдсэн Алтай ятгаас тод ажиглаж болно. Ийм төрлийн ятгын эх сурвалж эртний нүүдэлчдийн туйлсын хөгжмийн түүхэнд нэлээн хэд бий. Эх сурвалжийг тодруулбал:

(зураг 1) Шинжааны хойд хэсгийн Турфан хотын орчимд байх Янхайн оршуулгын газраас МЭӨ X зуунд хамаарах өнцөгт ятга, Шинжааны өмнөд хэсгийн Баянголын Монголын өөртөө засах тойргийн нутагт орших Жаганлукийн 1 болон 2-р оршуулгаас МЭӨ VIII–II зуунд холбогдох өнцөгт ятга [Төрбат, Батсух, Батбаяр 2014: 155–169], МЭӨ V зуунд хамаарах Памирын өндөрлөгөөс олдсон эртний нүүдэлчдийн өнцөгт ятгуудыг [Shen et al. 2015] нэрлэж болно. Эдгээр ятгууд нь Жаргалант Хайрханы модон хөгжимдүүрийн нэгэн адил 70–80 см урттай, 5 чавхдастай, 5 чавхдасандаа тохирсон тохой хэрийн цуурайн хайрцагтай, мөн тийм хэмжээний шулуун хүзүүтэй, чавхдасаа ороож чангалдаг, өлөн чавхдастай хөгжимдүүрүүд юм (зураг 2).



Зураг 1. Янхайн өнцөгт ятга (БНХАУ-ын Шинжаан-МЭӨ X зуун)






Зураг 2. Янхайн ятгын сэргээсэн байдал. Судалгааны зургийг Д. Ганпүрэв

## Д. Ганпүрэв Андураан дууг ангилал зүйгээр шинжих нь (хөгжмийн археологи судлалын илтгэл)

Шинжааны хойд хэсгийн Янхайн оршуулгаас илэрсэн өнцөгт ятгын цуурайн хайрцагны нүүрийг хонь ямааны арьсаар татаж хийхдээ нүүрний арьсыг тав зүсэж, нүхэнд нь шор гүйлгэж тээг татуургыг үйлдсэн байдаг. Энэ нь бусад ятгын олдворууд дээр мөн ижил үйлдэгдсэн тул эртний нүүдэлчдийн хөгжмийн туульсийн хөгжимдүүр мөн болохыг илтгэдэг.


Эртний нүүдэлчдийн эдгээр өнцөгт ятгууд нь «Алтан ундарга», «Хөх бодон» туулинд хайлагддаг «...Анхан живэрлэгийн дүүргэн Андураан дуун хүнкэнэдэг» өвөг туульсын хөгжимдүүр байгаад хаа нэгтээ устаж үгүй болох гадны шалтгаан байсан болов уу.

Урц ханатай болж Монгол гэрийн хөгжлийг үүсгэдгийн нэгэн адил (зураг 3) эртний нүүдэлчдийн өнцөгт ятга анхандаа шулуун хүзүүтэй үйлдэгдээд аажимдаа хөгжлийн явцдаа хүзүүгээ өргөж нуман хүзүүтэй өнцөгт ятгын төрөл зүйлийг хөгжүүлсэн ч хөгжлийн явцдаа хаднаан булшинд хадгалагдаж өнөө цагт дахин илэрч байгаа нь аяс намуун цагийн билэгдэл зүй талаасаа дахин сэргээгдэх түүхийн онцгой ховор боломж юм. Жаргалант Хайрханы хөгжмийн олдвор нь икэл хуурыг модон цартай болгодогийн нэгэн адил 1 500 жилийн өмнөх эртний нүүдэлчдийн хөгжмийн урлахуйн шинэ нээлтүүдийг нотлох хосгүй олдвор гэж ойлгогдохоор байгаа юм. Өвөг нүүдэлчдийн туульсын хөгжимтэй холбоотой дээрх ятгын олдворуудыг эртний нүүдэлчдийн хөгжимдүүрийн төрөлд хамааруулан олон улсын угсаатны хөгжмийн индекс # 322.13-д хамаарах Андуураан ятгын шинэ төрөл зүйлийг үргэлжлүүлэн хөгжүүлэх саналыг судлаачийн зүгээс санал болгож байна.



Зураг 3. Памирын олдвор, ЖХ-ны олдворын жишээн дээр археоакустик шийдлийг олох зорилгоор өнцөгт ятгаас нуман хүзүүтэй өнцөгт ятгад шилжсэн байдал

Д. Ганпурэв Андураан дууг ангилал зүйгээр шинжих нь  
(хөгжмийн археологи судлалын илтгэл)



Зураг 4. Андуураан ятга (lat. *Andura harps*)

Зураг 4 дээрх ятгууд нь эртний нүүдэлчдийн андуураан төрлийн ятгууд бөгөөд Алтайн өмнө хэсэгт оршдог тэнгэрийн уул, баруун хэсэгт оршдог Памирын өндөрлөг, зүүн хэсэгт оршдог Жаргалант Хайрханы Өмнөхийн амнаас олдсон туульсын хөгжимдүүрүүд юм. Түүхэн үечлэлээр нь жагсааж бичвээс

1. Янхайн өнцөгт ятга / МЭӨ X зуун
2. Жаганлукуын өнцөгт ятга / МЭӨ VIII–II зуун
3. Жаганлукуын өнцөгт ятга / МЭӨ VIII–II зуун
4. Памирын өнцөгт ятга / МЭӨ V зуун
5. ЖХ-ны нуман хүзүүт өнцөгт ятга / МЭ VII–VIII зуун гэх мэт 10 гаруй туульсын ятга бий. Түүхэн цаг үеэс хөгжлийг нь ажваас Памирын эх олдворын их бие нь Жаргалант Хайрханы олдвортой төстэй хэдий ч хүзүү нь тэгш. Сурвалжийг ажваас МЭӨ V зуунаас МЭ VII зууны хооронд туульсын хөгжимдүүрд хувьсал хийгдэж улмаар археоакустик орон зайг хөгжүүлэх зорилгоор тэгш хүзүүг нумлаж, цуурайн хайрцагны арьсан нүүр нь модоор үйлдэгдсэн үйл явц анзаарагдана.
6. ЖХ-ны олдворыг сэргээсэн байдал / Д. Ганпүрэв
7. ЖХ-ны олдворыг амилуулсан байдал / Д. Ганпүрэв

Эдгээр туульсын ятгууд нь бүгд 5 чавхдастай, түүндээ тохирсон нэг тохой хэрийн цартай. Үүгээрээ эртний Грек, Ассир, Олбиа, Пазырыкийн өнцөгт ятгуудаас эрс ялгагдах тул гарал үүсэл нь Алтайгаасаа үүдэлтэй, анчдын болон тал хээрийн нүүдэлчдийн 3 000 жилийн түүхтэй хөгжимдүүрүүд юм.

Тус судалгааны хүрээнд “Hornbostel-Sachs-Systematik” ангиллын индекс # 3 цуурайн хайрцагт чавхдаст хөгжимдүүрийн их айд хамаарах, индекс # 32 бүлгийн (322) босоо ятга (harps)-ын төрөл зүйлийг 2 биш 3 зүйлд хуваах саналыг үүгээр дэвшүүлж байна.

Үүнд: Индекс # 322.11 Нуман ятга (lat. *arched harps*)


Индекс # 322.12 Өнцөгт ятга (lat. *angular harps*)

Шинэ индекс # 322.13 Андуураан ятга (lat. *andura harps*)

санал болгож байна.

Д. Ганпурэв Андураан дууг ангилал зүйгээр шинжих нь  
(хөгжмийн археологи судлалын илтгэл)

Хүснэгт I. Жаргалант Хайрханы хөгжмийн  
олдворын ангилал, төрөл зүйл



СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2. Хөгжмийн эх олдворын нэр томъёоллын судалгаа

Жаргалант Хайрханы хөгжмийн олдворт нүүдэлчдийн угсаатны хөгжмийн судалгааг хийхийн тулд хөгжимдүүрийн нэр томъёог тодорхой болгох хэрэгтэй.

Хөгжмийн олдворт холбогдох нэр томъёог эх сурвалжид тулгуурлан судлах явдал нэн чухал бөгөөд цаашид уг нэршлээр нэрлэх, хөгжимдүүрийн дахин сэргээлтэнд ашиглах зэргээр үндсэн нэршлийг тогтоон хэрэглэх боломжтой. Нэр томъёо нь олон улсын хөгжмийн археологи судлал, угсаатны хөгжмийн судлал, орчин Үеийн хөгжмийн зэмсэг судлалын хүрээнд хийгдэх ба олон улсын болон монгол угсаатны хөгжмийн нэр томъёоллын харьцуулсан судалгаагаар жаргалант хайрханы хөгжмийн эх олдворын хөгжимдүүрийн эд ангийг нэрлэж дутууг нь гүйцээх зэргээр эх загварын анхдагч дүрийг сэргээнэ. Эртний болон нэн эртний хөгжимдүүрийн ижил төстэй шинжүүдийн хүрээнд цуглуулсан мэдээлэл, цуурайн хайрцагт чавхдаст хөгжимдүүрийн ангилал, төрөл зүйлийн судалгаа нь Жаргалант Хайрханы хөгжмийн эх олдворын угсаатны хөгжмийн судалгааг хийх боломжийг олгож байна.

Олон улс дахь чавхдаст хөгжимдүүрийн эд ангийн бүтцийн задаргаа нь 5 бүхэл хэсэг, 20 гаруй зүйл, зарим хөгжимдүүрүүд нь түүнээс ч олон эд ангиудаас бүрддэг билээ. Энэ нь:

- a) Толгойн хэсэг,
- b) хөгжмийн хүзүү,
- c) тулгуур багана,
- d) хөгжмийн цуурайн хайрцаг,
- e) Чавхдас болон туслах эд ангиудад хамаарна.

Энэ бүхнийг олон улсын нэршил, эд ангиудын хөгжимдүүрд гүйцэтгэх үүргийн хамт судалснаар олон улсын хөгжмийн ангилалын индекс # 321.1 хамаарах Морин хуур (lat. *Bow instrument*)

индекс # 321 хамаарах Домбр (lat. *Lute*)

**индекс # 322.1** нээлттэй ятга (lat. *Open harp*)

индекс # 322.11 хамаарах Африкийн Иннанга ятга (lat. *Arched harps*)

индекс# 322.12 хамаарах Янхайн енецгт ятгын олдвор (МЭО 1000 он) (lat. *Angular*)

**индекс # 322.2** хамаарах Хүрээт босоо ятга (lat. *Frame harps*)

зэрэг хөгжимдүүрийн эд ангийн нэршлийг Жаргалант Хайрханы модон хөгжимдүүртэй харьцуулан хүснэгт-2 үзүүлэв.

Д. Ганпурэв Андураан дууг ангилал зүйгээр шинжих нь  
(хөгжмийн археологи судлалын илтгэл)

Цуурайн хайрцагт чавхдаст хөгжимдүүрийн нэр томъёолол  
Хүснэгт 2. Угсаатны хөгжимдүүрийн эд ангийн нэршлийн харьцуулалт

№	Эд ангийн нэрс	#321.1	#321.2	#322.11	#322.12	#322.13	#322.2
		Bow	Lute	Open harps	Open harps	Open harps	Frame harps
		Нумт	Товшуур	Нуман ятга	Өнцөгт ятга	Өнцөгт ятга	Хүрээт ятга
		Морин хуур	Домбр	Адууну ятга	Янхай ятга	ЖА-ны хөгжим	Босоо ятга
1	Толгой	Морин толгой	Чангалуур ын суурь	Байхгүй	Гадасны суурь	Морин толгой	Байхгүй
2	Чавхдас чангалуур	Модон чих	Модон чих	Ороодост болон модон чих	Ороодост	Ороодост	Ороодост болон төмөр чих
3	Чангалуурын хайрцаг	Толгойн хэсэгт	Толгойн хэсэгт	Чангалагч багана	Чангалагч багана	Чангалагч багана	Чангалагч багана
4	Хүзүү	Шулуун	Шулуун	Нуман	Шулуун	Нуман	Шулуун
5	Цуурайн хайрцаг	Дөрвөлжин	Бүтэн саран	Тэвшин цартай	Тэвшин цартай	Шанаган цартай	Шулуун тэвшин
6	Цуурайн хайрцагны ар хэсэг, хажуу хэсэг, нүүрэн хэсэг	Нийлүүлж наасан, дөрвөлжин	Бүтэн саран, хүрээлж хашсан	Ухаж үйлдсэн	Ухаж үйлдсэн	Ухаж үйлдсэн	Үргэлж
7	Чавхдас тагач тээг мод болон чавхдасыг тэвхдэх тэвх мод	Тэвхтэй	Тэвхтэй	Царнаас шууд	Царнаас шууд	Тээг модтой	Царнаас шууд
8	Эгшиг цацруулагч нҮх	F - нүх	O - нүх	O-нүх	X-нүх	X-нүх	I - нүх
9	Чавхдас	Хялгасан	Нийлэг	Шөрмөсөн	Элэн	Өлөн	Нийлэг
10	Чавхдасын тоо	2	4-6	8-12	5	5	18-26

2.1. Эх олдворын бүтэц, нэршлийн томъёолбор схемийг загварчилах нь

Эх олдворын хөгжимдүүрийн бүтцийн нэрс хийгээд хөгжмийн эх олдворт тодорхойлж болох эд ангийн нэрсийг (А),

хөгжмийн эх олдворт алга болсон бөгөөд нөхөн сэргээх шаардлагатай эд ангийн нэршилгээ (В) гэж 2 ангилан тэмдэглэж байна.

(А) Хөгжимдүүрийн бүтцийн нэршил ба хөгжмийн эх олдворт тодорхойлж болох эд ангийн нэршилгээг их биений хөндлөн хэсэгт гурав хувааж ангилна. Үүнд: (А<sub>1</sub>) толгойн хэсэг, (А<sub>2</sub>) нуман хүзүүний хэсэг, (А<sub>3</sub>) цуурайн хайрцагны хэсэг. Эдгээр гурван хэсгийн нэрсийг схем дээр улаан өнгөөр бичиж тэмдэглэв.

(В) хөгжмийн эх олдворт алга болсон бөгөөд нөхөн сэргээх эд ангийн нэршилгээг тодорхойлж болох нэрээр нь нөхөн сэргээж бичсэн бөгөөд үүнийг (b<sub>1</sub>) чавхдас чангалагч багана, (b<sub>2</sub>) чавхдас, (b<sub>3</sub>) бэхэлгээний шаантаг мод (эсвэл төмөр) хэмээн нэрлэв. Эдгээр дутуу эд ангийн нэрсийг схем дээр цэнхэр өнгөөр тэмдэглэв.

Схем дээрх нэршлийг ялгаж, задалж шинжлэхийн тулд хөгжмийн эх олдворыг координатын абсцисс буюу хэвтээ тэнхлэгийг ашиглав.

### Эх олдворын бүтэц, нэр нэршлийн томъёолбор схем

[Ганпүрэв 2014]

(А <sub>1</sub> ) ТОЛГОЙ			(А <sub>2</sub> ) НУМАН ХҮЗҮҮ						(А <sub>3</sub> ) ЦУУРАЙН ХАЙРЦАГ									
С-	1	2	3	4	5	6	7	8	9 1	2	3	4	5	6	7	8	9	
Дагзны арын нүх (А <sub>1.01</sub> )	(В1)Чавхдас чангалагч багана						Цуурайн хайрцагны нүүр (А <sub>3.01</sub> )											
	(В3) Чавхдас						Хүзүүний угийн хээ (А <sub>2.05</sub> )	Царны дээд хэсэг (А <sub>3.03</sub> )			Царны дунд хэсэг (А <sub>3.04</sub> )			Царны доод хэсэг (А <sub>3.05</sub> )				
	(В2)Бэхэлгээний шаантаг							Царны бөөрөн дээрх нүх (А <sub>3.10</sub> )			Царны нүүрэн дээрх нүх (А <sub>3.11</sub> )							
Чихний арын нүх (А <sub>1.02</sub> )	Хүзүүний шил (А <sub>2.02</sub> )						Хүзүүний угийн нүх (А <sub>2.05</sub> )	Царны бөөр (А <sub>3.06</sub> )		Тээг мод (А <sub>3.08</sub> )		Царны сүүл/бөгс (А <sub>3.07</sub> )						
	Руни бичээс (А <sub>2.04</sub> )																	
	Бүдэрхий (А <sub>2.01</sub> )			Ороолт (А <sub>2.03</sub> )														
А-	Эх олдвор дээрх нэр томъёол									авиа цацагч (X) - Аясын нүх (А <sub>3.09</sub> )								
В-	Дутуу эд ангиуд									Цуурайн хайрцагны ар ба цүлхэн (А <sub>3.02</sub> )								

Зураг 5. Эх олдворын бүтэц, нэршил тогтоох схем

Хөгжмийн эх олдворын их биеийг А<sub>1</sub> / А<sub>2</sub> / А<sub>3</sub> гэсэн гурван хэсэгт хуваав. Хөгжимдүүрийн энэ гурван хэсэгт хамааралтай, тодорхойлж болох эд ангийг (А)-д нь үлдээж, нөхөн сэргээх эд ангиудыг (В) үсгээр тэмдэглэв.

Координатын абсцисс буюу хэвтээ тэнхлэгийг (С) үсгээр ялгаснаар хөгжмийн эд ангийг олох, нэрлэхэд илүү дөхөм болохоос гадна судалгааны тэмдэглэгээг ялгаж, уялдаа холбоог нь танихад тусална. Эд

**Д. Ганпурэв Андураан дууг ангилал зүйгээр шинжих нь  
(хөгжмийн археологи судлалын илтгэл)**

ангийн нэршлүүдийг ялгаж салгахын тулд эдгээр тэмдэглэгээг нэрний ард хаалтанд оруулав.

Жишээлбэл:

**Тайлбар-1.** Тээгч мод нь цуурайн хайрцагны нүүрэнд наалттай олдсон тул  $A_3$  хэсэгт хамаарна.  $A_3$  хэсэгт хамаарах хөгжмийн эх олдворын 11 эд зүйлийн 8 дахь эд анги нь тээгч мод тул жижиг (о) Үсгээр ялгаж о8 гэж тэмдэглэв.

Эх олдворын бүтэц, нэр, нэршлийн томъёолборын схем дээр тэмдэглэхдээ «Тээгч мод» ( $A_3$ .о8) бөгөөд байршлыг олохдоо схемийн  $A_3$  координатын абсцисс C4-5 гэж олно. Ерөнхий тэмдэглэгээ нь ( $A_3$ .о8./C4-5) болж байна.

**Тайлбар-2:** Чавхдас чангалах зориулалт бүхий багана нь хөгжмийн эх олдвороос алга болсон, нөхөн сэргээх эд анги мөн тул зөвхөн “B” үсгээр ялгана.

Координатын абсциссын хэвтээ тэнхлэгийн хуваарь нь:

« $A_1$ » хэсэг нь  $A_3/C1-2$

« $A_2$ » хэсэг нь  $A_2/C3-9$

« $A_3$ » хэсэг нь  $A_3/C1-9$  -д хамаарна.

Координатын ординатын босоо нэршлийг  $A_1/A_2/A_3$  -аар тодорхойлно.

Эх олдворын бүтэц, нэр нэршлийн томъёолборын схем дээрх тэмдэглэгээг мөрдөж хөгжимдүүрийн бүх эд ангийн судалгааг хураангуйлан томъёолборын тайлбарыг товчлон бичвээс:

**(A) Их бие (абсцисс A1/C1-2, A2/C3-9, A3/C1-9)** Хөгжмийн эд ангиудаас энэ хөгжмийн өнөө цагийн төрхийг нуусан хоёр эд анги бий. Энэ нь (a) нуман хүзүү, (b) тээгч мод болно. Их биений өргөн 10,1 см, урт нь 72 см.

**(A<sub>1</sub>) Толгойн хэсэг (абсцисс A<sub>1</sub>/C1-2)** Толгой нь адууны шанаа шиг өргөө, дээрээ хөзхөлтэй, хонишоор завьж нь морь лугаа адил тул олон шинжээр нь морин толгой гэдэгтэй судлаачид санал нийлэх байх.

Хөгжмийн толгойн хэмжээ чихний үзүүрээс хонишоор хүртэл 5,3 см.

**A<sub>1</sub>.o1. Дагзан дээрх нух ба багана модны суурь (абсцисс A<sub>1</sub>/C1-2)** Хөгжим дүүрийн дагзны оройгоос аман хүзүүг нэвт цоолсон дөрвөөлжин нух нь (B1) чавхдас чангалах багана модонд зориулсан углуурганы суурь нух юм. Хэмжээ нь 9 смхб,4 мм.

**B1.-A1.o1. Чавхдас чангалагч багана мод (абсцисс A1/C1-2)** Нөхөн сэргээх чавхдас чангалагч багана мод нь A1.o1 дагзны арын нүхэнд бэхлэгдэх толгойн хэсгийн нөхөн сэргээгдэх эд анги юм. Дагзны суурь нүхний хэмжээ 8,6хб,8 мм тул толгойн өндөртэй харьцуулсны дагуу 0,5 см-ээр (хэмжээгээр нь) өргөтгөөд 1,86–2,0 см-ийн өргөнтэй, углуургын урт нь 3,6 см багана мод байрлах боломжтой.

**A<sub>1</sub>.o2. Чихний арын нух ба бэхэлгээний нух (абсцисс A<sub>1</sub>/C1-2)** Эх олдворын толгойн чихний ард нэвт нух бий. Энэ нух нь чавхдас чангалах

баганын суурийг хөдөлгөөнгүй барих зориулалттай (B2) шаантаг модонд зориулсан нүх юм.

**B2.-A1.02. Бэхэлгээний шаантаг (абсцисс A1/C1-2)** Бэхэлгээний шаантаг нь (B1) чангалуур багана модыг хөдөлгөөнгүй барих зориулалттай хийгдсэн бөгөөд шаантагийг (A1.02) чихний ард нүхэлсэн нь (A1.01) дагзан дээрх нүхтэй тохирч байгаа юм.

**(A2) Нуман хүзүүний хэсэг (абсцисс A<sub>2</sub>/C3-9)** Хөгжмийн эх олдворын хүрүү нь цуурайн хайрцагаас үргэлжид хийгдсэн бөгөөд их биенийхээ холбогч хэсэг нь юм. Хүзүүий шулуун хэмжээ 31 см.

**A<sub>2</sub>.01. Хүзүүний бүдэрхий (абсцисс A<sub>2</sub>/C3-9)** Хөгжмийн эх олдворын хүзүүний урд хэсгийг хөгжимдүүрийн бүдэрхий гэж нэрлэнэ. Жаргалант Хайрханы хөгжмийн эх олдвор нь Монгол угсаатны хөгжимдүүрүүдийн дунд байдаггүй урт нумласан хүзүүэй тул энэ нэршил нь зөвхөн эх олдворын нэршилийн судалгаанд хамаарна. Хүзүүний бүдэрхийний хэмжээ 34 см.

**A<sub>2</sub>.02. Хүзүүний шил ба зоо (абсцисс A<sub>2</sub>/C3-9)** Хөгжмийн эх олдворын хүзүүний дээд хэсгийг «Хүзүүний шил» гэж нэрлэнэ. Нэршилийн хувьд нуман хүзүүнд хамаарна. Хүзүүний шилийг хүзүүний зоо гэж нэрлэж болно.

**A<sub>2</sub>.03. Хүзүүний хальсан ороолт (абсцисс A<sub>2</sub>/C3-9)** Хөгжмийн эх олдворын нумласан хүзүүг ямар нэгэн бутлаг модны нимгэн хальсаар ороосон нь тухайн хөгжмийн чимэглэлийн зориулалттай болохоос хөгжимд сул үүрэгтэй ороолт юм. Хүзүүний хальсан ороолт 3,5 мм.

**(A2) A2.04 Руни бичгийн бичээс (абсцисс A2/C6-A3/C6)** Жаргалант Хайрханы хөгжимдүүр нь эх олдворын нуман хүзүү болон цуурайн хайрцагны цулхэний дээд хэсгийн хоёр талдаа 6 мөр, 60 илүү тэмдэгтэй руни бичгийн дурсгалтай олдсон. 2014 онд МУИС-ийн Түрэг судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, проф. Ц. Баттулга эртний руни бичээсийг тайлахдаа хөгжимдүүрийн нэр нь Яаялиг (монг. аялага), хөгжмийн эзнийг нь Чүрэ гэж хөрвүүлэн буулгажээ [Баттулга 2014: 171–179].

**A<sub>2</sub>.05. Хүзүүний угийн дээд хэсэг дэх ташуу дөрвөлжин хээ (абсцисс A2/C8-9)** Хөгжмийн эх олдворын хүзүүний угийн дээд хэсэг буюу (A2.02/C8-9) хүзүүн зоонд хоёр тийш ташуулдан зурчин сийлсэн ташуу дөрвөлжийн хээ байдаг. Анхандаа ямар нэгэн тэмдэгт шиг харагдана. Аливаа хээ нь чимэглэлийн зориулалттай байдаг бол эх олдвор дээрх ташуу дөрвөлжин зураасууд нь хээ биш, наалттай холбоотой гөлгөр гадаргуу дээрх зурчин сараачсан болно, зурчин сийлсэн нь ташуу дөрвөлжин хээний урт нь 5,5 см.

**A<sub>2</sub>.06. Хүзүүний угийн нүх ба сойлго уяаны нүх (абсцисс A2/C8-9)** Хөгжмийн олдворын (A2/C9) нуман хүзүүний уг, цуурайн хайрцагны дээд үзүүрт, их биений яг гол хэсэгт хөндлөн цоолсон нүх бий. Зориулалт нь

**Д. Ганпурэв Андураан дууг ангилал зүйгээр шинжих нь  
(хөгжмийн археологи судлалын илтгэл)**

хөгжимдүүрийн тэнцвэрийг хадгалах болон ханын толгойд өлгөх зэрэг сойлгын зориулалттай нух байж болхоор. Хэмжээ нь 0,47 мм.

**(Аз) Цуурайн хайрцагны хэсэг (абсцисс Аз/С1-9)** Цуур, суур, хуур, цуурай, чура, чурэ, чур-гөөлгөн, шөр-гөөлөн зэрэг нь эртний өвөг туулинд байдаг хөгжимдөх, аялгуулах гэсэн утгатай дүйнэ. Энэ бүхний үүтгэл нь цуурай юм. Цуурайг дэмжих орон зайн савыг торх, бортог гэж нэрлэх бөгөөд орчин үеийн хөгжмийн нэрэнд цар гэж нэрлэдэг. Цар нь цуураинд зориулагдсан тул түүнийг цуурайн хайрцаг гэж нэрлэх нь хөгжмийн олдворт илүүтэй дөхөм сонсогдох тул ийнхүү нэрлэв. Хөгжмийн олдворын (Аз) цуурайн хайрцагийн хэсэгт нийт 11 эд ангийн нэр хамаарна. Цуурайн хайрцагны урт нь 37,3см, өргөн нь 10,5см.

**(Аз.01) Цуурайн хайрцагны нуур (абсцисс Аз/С1-9)** Цуурайн хайрцагийг урлахаас өмнө цуурайн хайрцагны нүүрийг ойролцоогоор 5 см зузаан хөрөөдөж авах нь хөгжимдүүрийн урлахуйн хувьд хамгийн зөв шийдэл бөгөөд нүүрний хавтасыг хоёр талаас нь илүүрдэж, харуулдаж ойролцоогоор 1,79 мм-ээс 4,21 мм нимгэнтэй засаж зүүдэл үгүй үйлдсэн нь үр дүй сайтай чадварлаг урлаачийн танигдсан бүтээл мөн болох нь танигддаг. Царны нүүрний нимгэн нь 1,2 см / зузаан 3,2 мм.

**(Аз.02) Цуурайн хайрцагны ар тал ба арын цүлхэн (абсцисс АЗ/С1-9)** Цуурайн хайрцагны ар талыг бусад хөгжимдүүрийн нэгэн адил тэгш бус гэдэстэй цүлхийлгэж урласан тул арын цүлхэн гэж нэрлэнэ. Цуурайн хайрцагны арын цүлхэний гадаргуу дээр түүхийн утга соёлын дахин давтагдашгүй хосгүй хоёр өвийн дурсгал бий. (1) Нуман хүзүү болон цүлхэний дээд хэсгийн бөөрийг дагасан 6 мөр бүхий 60 гаруй тэмдэгт бүхий эртний нүүдэлчдийн бичиг үсгийн дурсгал, (2) Цуурайн цүлхэн дээр ан авын өгүүлэмжтэй сийлмэл зураг. Энэ дурсгалаараа хун төрөлхтний утга соёлын унэт өв болно.

**(АЗ.03)** Цуурайн хайрцагны дээд хэсэг нь (абсцисс АЗ/С1-3)

**(АЗ.04)** Цуурайн хайрцагны дунд хэсэг нь (абсцисс АЗ/С4-6)

**(АЗ.05)** Цуурайн хайрцагны доод хэсэг нь (абсцисс АЗ/С7-9)

**(АЗ.06)** Цуурайн хайрцагны хоёр талын бөөр нь цуурайн цүлхэнд хамаарах ба баруун, зүүн гэж хувааж хэлнэ.

**(АЗ.07)** Цуурайн хайрцагны бөгс нь (АЗ.04) цуурайн хайрцагны доод хэсгээс тусдаа ойлголт бөгөөд цуурайн цүлхэндээ хамаарна.

**(АЗ.08) Тээг мод (абсцисс АЗ/С4-5)** Хөгжмийн олдворын онцлог нь Монгол угсаатны хөгжимдүүрийн төрөл зүйлд өнөөдрийг хүртэл илрээгүй босоо чавхдаст өнцөгт ятгын биет олдвор юм. Түүнийг босоо чавхдастай болгож байгаа ад анги нь цуурайн нүүрэн дээр байгаа хөндлөн тээг мод юм. Тээг мод нь чавхдас татах 5 сүвтэй байсан нь эх олдворын судалгаагаар тогтоогдсон. Тээг модны босоо байрлалтай таван сүвээс татагдах чавхдасны хэлбэр нь босоо ятга лугаа адил тул нумаар тоглох боломжгүй, хүзүүн дээр нь чавхдасыг дарж аясын шат

үүсгэх оролдлого хийгээд ч нэмэргүй, цорын ганц тоглож болох хувилбар нь ятга мэт чавхдасыг нь этэж тоглох арга юм.

**(Аз.09) Авиа гаргагч Х-Аясын нүх (абсцисс Аз/С5)** Бүх төрлийн хөгжимдүүрт аясын нүх эсвэл түүнийг орлуулах ямар нэгэн авиа цацагч зүйл бий. Үүнийг *f*-нүх (*Hole or F-hole*) гэж нэрлэнэ. Жаргалант Хайрханы хөгжмийн олдворын авиа гаргагч нүхийг хэлбэрийн хувьд (Х)-аяс цацагч нүх гэж нэрлэнэ. (Х)-аяс цацагч нүхний хэмжээ 2,0 см х 2,4 см, өргөн нь 0,4 см.

**(Аз.010) Цуурайн хайрцагны царны зүүн бөөрөн дээрх нүх (абсцисс Аз/С3)** Энэ нүх нь тулгуурын зориулалттай биш хүндийн төвийг тэнцүүлэх зорилготой сойлтуурын нүх байж магадгүй. Цуурайн цүлхэний дээд зүүн бөөрөнд байгаа (Аз/С3) жижиг нүх нь зүүн гарын чигчий, ядам хурууны сойлгонд зориулсан, харин хүзүүний угт байгаа (А2.05/С9) нүх нь 2 зориулалттай, энэ нь (1) өлгөх зориулалттай, (2) баруун гарын чигчий, ядам хуруунд зориулагдсан тоглолтын ур дүйтэй холбоотой сойлго уяанд зориулагдсан нүхнүүд байх боломжтой. Царан дээрх том нүхний хэмжээ 8х8,2 мм.

**(Аз.11) Цуурайн хайрцагны нүүрэн дээрх жижиг нүх (абсцисс Аз/С5)** Энэ жижиг нүх нь цуурайн хайрцагны нүүрэн дэх тээг модны зүүн талын ирмэг газарт бий. Тодруулж ажиглаваас хадаасны мөр ч байж болхоор. Цуурайн цүлхэний торхны ирмэг газрыг онож цохиогүйгээс нүүрний зүүн талын ирмэг хэсгээс 0,5 см хуртэй хугарч гээгдэх шалтгаан болсон байж мэдэхээр. Цуурайн хайрцагны нүүр бүтэн наалттай байсан бол тээг модны нэгэн адил бүтэн гарах магадлалтай.

**(В2) Хөгжмийн эх олдворын чавхдас.** Эртний нүүдэлчдийн цуурайн хайрцагт хөгжимдүүрд хэрэглэж болох гурван төрлийн чавхдас Монгол угсаатны хөгжимдүүрд өнөөдрийг хүртэл хэрэглэгдэж ирсэн. Үүнд:

- a) Өлөн чавхдас (engl. gutstrings)
- b) Шөрмөсөн чавхдас (engl. tendonstrings)
- c) Хялгасан чавхдас (engl. Horse hair strings)

Жаргалант Хайрханы хөгжимдүүрийн чавхдас нь тээг модон дээрх чавхдасны мөр, сүвээс хамаараад өлөн чавхдас хэрэглэх нь илүүтэй тохиромжтой. Хөгжмийн зэмсгийн нийт урт нь 72 см гэж үзвэл ойролцоогоор 60–65 см урт өлөн чавхдас хэрэглэж байсан.



*Photo 1. Эх олдворын бүтэц, нэр нэршлийн томъёолбор схемийг ашиглан Жаргалант Хайрханы хөгжмийн олдворын анхдагч загварыг сэргээсэн байдал / Судлаач Д. Ганпүрэв*

*Түүхэн цаг үе улирч хуучин бүхэн шинийн эхлэл болдог шиг анхан живэрлэгийн дүүргэн андуураан дуун дахин хүнкэнэж Алтай ятгын эх олдворын анхдагч загварыг ийнхүү дахин сэргээв.*

#### Дүгнэлт

Жаргалант Хайрханы хөгжмийн эх олдвор нь түүх археологийн судалгааны хүрээнд харьцангуй сайн судлагдсан судлагдахуун мөн боловч угсаатны хөгжим судлалын хүрээнд бүрэн судлагдаагүй учраас энгийн ард иргэд, судлаачдын дунд эх олдворын талаар олон янзын таамаглал үүсэх шалтгаан бий болсон. Жишээлбэл, төрийн таван чавхдаст ятга, тульсын товшуур, Туркийн саз, Казакын кобуз, Монголын морин хуурын өвөг гэх мэт нь энэхүү судалгааны өгүүллийг бичих үндэслэлүүдийн нэг юм.

Ховд аймгийн Жаргалант Хайрханаас олдсон хөгжмийн эх олдворыг дахин сэргээх судалгааны аргазүй, ангилал, бүтэц, нэр, нэршлийг тогтоохоос гадна эх олдворын анхны (дүр) загварчиллыг судласнаар олон нийтэд шинжлэх ухааны бодит мэдээллийг танилцуулахыг зорьсон. Хөгжмийн эх олдворыг судлахын тулд олон улс дахь Prehistoric, ancient хөгжмийн судалгаануудтай харьцуулж, Монгол угсаатны хөгжимдүүрийн болон олон улсын хөгжмийн ангилалд хамаарч болох археологийн хөгжмийн олдвор, угсаатны хөгжимдүүр, өнөө цагийн хөгжимдүүрийн ангилал зүйн харьцуулсан судалгаануудыг хийсэн.

Судалгааны үндсэн дээр хөгжмийн эх олдворын бүтэц, нэр нэршлийн томьёолборын схемчиллийг зохиосон. Схемийн дагуу эх олдворын эд ангиудад нэршил тогтоож дутуу эд ангийг нөхөж судалснаар Жаргалант Хайрханы хөгжмийн эх олдворын анхдагч загварыг дүрслэлийг сэргээсэн.

**Хөгжмийн археологи судлалын хүрээнд:**

1. Эртний нүүдэлчдийн нуман хүзүүтэй өнцөгт ятгын ангилалд Жаргалант Хайрханы хөгжимдүүр хамаарах болохыг тогтоосон.
2. Өвөг Монгол тууль болох «Алтан ундарга», «Хөх бодон» туулиудын бүлэг, бадаг холбоосоос үүдэж “Hornbostel-Sachs-Systematik” ангилалын индекс #322-ын 13-р зүйлд Андүүраан хүнгэнээнт ятгын бүлийг шинээр нэмэх санал гаргаж байна.
3. Энэ хөгжимдүүр нь тал хээрийн нүүдэлчдийн өнцөгт ятгын архео-акустик авиаг шийдэж туульсын хөгжимдүүрт авиа зүйн шинэчлэлийг тухайн үедээ хийсэн байх магадлалыг гаргаж тавьсан.
4. Эртний нүүдэлчдийн аман яруу найраг, өвөг туульд хөгжимдэхүйн соёлын нөлөө байсныг нотлох цорын ганц биет сурвалж мөн болохыг нотолж байна.
5. Үүгээр МЭ-ний VII зуунд Монголын газар нутаг дээр модон хөгжимдүүрийн урлахуйн соёл өндөр хөгжсөнийг тэмдэглэв.
6. Энэ бүхнийг судалсанаар Монгол угсаатны хөгжмийн бодит түүхийг МЭ-ний VII зуун хүртэл урагшлуулахыг зорьлоо.

Хөгжмийн эх олдвор нь нуман хүзүүндээ эртний бичээсийн дурсгалтай, царны цүлхэндээ ан хомрогын сийлмэл зурагтай бөгөөд энэ нь өвөг Монголчуудын соёлын дахин давтагдашгүй утга соёлын үнэт өв мөн болохыг монголын түүх, археологичид төдийгүй Германы эрдэмтэд нотолдог бөгөөд эх олдвор нь Монголын Түүхийн Музейн сан хөмрөгт хадгалагдаж байна.

**Номзүй**

- Both 2009 — *Both A. A. Music Archaeology: Some Methodological and Theoretical Considerations // Yearbook for Traditional Music. 2009. Vol. 41. Pp. 1–11.*
- Вертков, Благодатов, Язовицкая 1963 — *Вертков К. А., Благодатов Г., Язовицкая Э.* Атлас музыкальных инструментов народов СССР. М.: Музгиз, 1964. 275 с.
- Hornbostel, Sachs 1914 — *Hornbostel E. M., Sachs C. Systematik der Musikinstrumente. Ein Versuch. In: Zeitschrift für Ethnologie. Band 46. 1914. N. 4–5. Pp. 553–590.*
- Sachs 1940 — *Sachs C. The History of Musical Instruments. New York: W. W. Norton & Company, 1940. Pp. 463–467.*
- Shen et al. 2015 — *Shen H., Wu X., Tang Z., Zhou X., Sun N., Li X. Wood Usage and Fire Veneration in the Pamir, Xinjiang, 2500 yr BP // PLoS ONE. 2015. 10(8): e0134847. <https://doi.org/10.1371/journal.pone.0134847>*

**Д. Ганпүрэв Андураан дууг ангилал зүйгээр шинжих нь**  
**(хөгжмийн археологи судлалын илтгэл)**

- Баттулга 2014 — *Баттулга Ц.* Жаргалант Хайрханы хөгжмийн зэмсэг дээрх эртний бичээс // Талын морьтон дайчдын өв соёл. Улаанбаатар, 2014. Х. 171–179.
- Ганпүрэв 2014 — *Ганпүрэв Д.* Эх олдворын бүтэц, нэр нэршлийн томъёолбор схемийн зураг. (Хувийн судалгааны архив). Улаанбаатар, 2014.
- Ганпүрэв 2020 — *Ганпүрэв Д.* Магистрын судалгааны бүтээл // Хөгжмийн эх олдворын нэр томъёоллын судалгаа. Улаанбаатар, 2020. Х. 38–64.
- Төрбат, Батсүх, Батбаяр 2014 — *Төрбат Ц., Батсүх Д., Батбаяр Т.* Жаргалант хайрханы хөгжимийн зэмсэг // Талын морьтон дайчдын өв соёл: VII–XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн. Ред. Ц. Төрбат, У. Эрдэнэбат. Улаанбаатар, 2014. Х. 155–169.